



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/218

Улаанбаатар хот

Сэтгүүл эрхлэн гаргах журам, сэтгүүлийн зөвлөлийн  
бүрэлдэхүүн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гамшиг судлал, инноваци" онол, практик, аргазүйн мэргэжлийн сэтгүүлийг эрхлэн гаргах журмыг нэгдүгээр, сэтгүүлийн зөвлөлийн бүрдэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сэтгүүлийн бүтцийг зөвлөлөөр хэлэлцэн, хагас жил тутам эрхлэн гаргах ажлыг зохион байгуулж, нийтийн хүртээл болгохыг Сэтгүүлийн ерөнхий эрхлэгч, дэд дарга (хурандаа Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Сэтгүүлийг улсын бүртгэлд бүртгүүлэх, гэрчилгээ, оюуны өмчийн индекс авах, Шинжлэх ухааны академийн холбогдох салбарын Бага чуулганаар хэлэлцүүлж, эрдэм шинжилгээний бүтээл нийтлэх эрх авах ажлыг үе шаттай гүйцэтгэхийг Сэтгүүлийн эрхлэгч, Гамшиг судлалын хүрээлэнгийн захирал (хурандаа Д.Алтангэрэл)-д даалгасугай.

4. Сэтгүүл хэвлэн гаргах зардлыг 2019 оны төсөвт суулгаж, санхүүжүүлэх ажлыг зохион байгуулахыг Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газар (дэд хурандаа Я.Гантөмөр)-т даалгасугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2018 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн  
А/218... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**"ГАМШИГ СУДЛАЛ, ИННОВАЦИ" ОНОЛ, ПРАКТИК, АРГАЗҮЙН  
МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛИЙГ ЭРХЛЭН ГАРГАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмаар Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөл, Гамшиг судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргах "Гамшиг судлал, инноваци" онол, практик, аргазүйн мэргэжлийн сэтгүүлийг (цаашид "сэтгүүл" гэх) эрхлэн гаргахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Сэтгүүл нь гамшиг судлалын шинжлэх ухааны онол, практик, арга зүйн мэргэжлийн цуврал сэтгүүл байх бөгөөд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчин, практикт тулгамдсан асуудлыг шинжлэх ухаан, онол, арга зүй, технологи, зохицуулалтын хүрээнд уламжлал, шинэчлэлийг хослуулан шийдвэрлэх талаар эрдэмтэн, судлаачдын шинжлэх ухаанч сэтгэлгээг дэмжих, тэдний үзэл бодол, дүгнэлт санал, судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгох, гамшгаас хамгаалах талаарх төрийн бодлогыг сурталчлахад дэмжлэг үзүүлнэ.

1.3. Сэтгүүлийн үүсгэн байгуулагч нь Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн байх бөгөөд сэтгүүлийн нэрийг эзэмших эрх нь үүсгэн байгуулагчид хадгалагдана. Сэтгүүлийн үйл ажиллагаа ашгийн төлөө бус байна.

1.4. Сэтгүүл шуудангийн болон цахим хаягтай байна. Сэтгүүлийн албан ёсны хаяг нь Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгийн хаяг байх бөгөөд цахим шуудангийн хаяг нь сэтгүүлийн оноосон нэрийг агуулсан байна.

**Хоёр. Нийтлэлийн бодлого, үндсэн агуулга**

2.1. Сэтгүүлийн нийтлэлийн бодлого нь гамшгаас хамгаалах салбарт онол, практикийн хувьд тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны онол, арга зүйн үүднээс шийдвэрлэх арга замыг тодорхойлох, судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, ололтыг амьдралд нэвтрүүлж инноваци болгох аливаа шинжлэх ухаанч, бүтээлч санал, санаачилгыг хөхиүлэн дэмжихэд оршино.

2.2. Сэтгүүлд нийтлэх бүтээлийг дараах дэс дарааллыг харгалзан байршуулна.

- I. Гамшгаас хамгаалах бодлого, эрх зүй
- II. Гамшгаас хамгаалах судалгаа, эрдэм шинжилгээ
- III. Гамшгаас хамгаалах салбарын түүхэн хөгжил, шинэчлэл
- IV. Эрдэмтэн, судлаачдын үзэл бодол
- V. Дэвшилтэт технологи, инноваци
- VI. Олон улсын туршлага, сургамж

2.3. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд уг бүтээлийн ашиглалт, эрхийн хамгаалалт нь хууль, тогтоомжид заасны дагуу хамгаалагдсан байна. Сэтгүүл бүхэлдээ ISSN бүртгэлээр баталгаажихаас гадны зохиогчийн эрхийн гэрчилгээ Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгийн нэрээр авна.

## **Гурав. Сэтгүүлийн удирдлага, зохион байгуулалт**

3.1. Сэтгүүлийн удирдлагыг Сэтгүүлийн зөвлөл (цаашид "зөвлөл" гэх) хэрэгжүүлнэ.

3.2. Сэтгүүлийн зөвлөл нь ерөнхий эрхлэгч, эрхлэгч, гишүүн, хариуцлагатай нарийн бичгийн дарга, техник редакторыг оролцуулан 9-өөс доошгүй гишүүнтэй байна. Зөвлөлийн гишүүдийг 2 жил тутамд шинэчлэх бөгөөд ийнхүү шинэчлэх нь гишүүнийг улиран ба дахин сонгогдоход харшлахгүй болно.

3.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн ба түүний эрх хэмжээ

3.3.1. Зөвлөлийн гишүүнд гамшгаас хамгаалах салбарын эрдэмтэд, Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтан, гамшгаас хамгаалах талаар судалгаа, эрдэм шинжилгээний дорвитой бүтээл туурвисан бусад салбарын нэр хүнд бүхий эрдэмтэдийг оруулна.

3.3.2. Зөвлөлийн хуралдааныг Ерөнхий эрхлэгч зарлан хуралдуулна. Зөвлөлийн гишүүдийн 50-иас дээш хувь хүрэлцэн ирсэн тохиолдолд хурал хүчинтэйд тооцогдох бөгөөд шийдвэрийг оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар гаргана.

3.4. Сэтгүүлийн зөвлөлийн эрх, үүрэг

3.4.1. Сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих, сэтгүүлийг цаашид хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлно.

3.4.2. Сэтгүүлийн нэр, билэгдэл, хавтас дизайныг батлах, өөрчлөх асуудлыг шийдвэрлэж, сэтгүүлийн нийтлэлийн бодлого, чанарт үнэлэлт, дүгнэлт өгч ажиллана.

3.4.3. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээлийг агуулгын хувьд хянаж уг бүтээлийг цаашид сэтгүүлд нийтлэх эсэх талаарх дүгнэлт, эсхүл цаашид бүтээлийг сайжруулах талаарх санал гаргана.

3.5. Сэтгүүлийн ерөнхий эрхлэгчийн эрх

3.5.1. Сэтгүүлийн дугаар бүрийн эцсийн төсөлтэй танилцан, хэвлэлтэд шилжүүлэх шийдвэр гаргана.

3.5.2. Сэтгүүл эрхлэн гаргахтай холбоотой зардал, ажлын хөлс, урамшуулал олгох асуудлыг Онцгой байдлын ерөнхий газрын даргаар шийдвэрлүүлнэ.

3.6. Сэтгүүлийн эрхлэгчийн эрх, үүрэг

3.6.1. Сэтгүүлийг эрхлэн гаргах ажлыг хариуцаж ажиллана.

3.6.2. Сэтгүүлийг эрхлэн гаргахтай холбоотой шийдвэрлэх асуудал, тайлан мэдээг зөвлөлөөр хэлэлцүүлэн, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллана.

3.6.3. Сэтгүүлийн бүтээлийг чанаржуулах зорилгоор онцгой байдлын байгууллага, их, дээд сургууль, судалгааны хүрээлэн, төв, төрийн бус болон иргэний нийгмийн байгууллага, гадаадын эрдэмтэн, судлаачдыг бүтээл нийтлүүлэхэд анхаарч, санаачилга, үр дүнтэй ажиллах, хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллана.

3.7. Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн даргын эрх, үүрэг

3.7.1. Сэтгүүлд нийтлүүлэх бүтээлийг хүлээн авч, бүртгэлд хамруулах, нэгтгэн сэтгүүлийн эрхлэгчтэй зөвшилцөн зөвлөлийн гишүүдэд бүтээлийг хянуулахаар хуваарилна.

3.7.2. Сэтгүүлийн стандартад хяналт тавих, хэвлэлд бэлтгэх, хугацаанд нь хэвлүүлэх, сэтгүүлийн сурталчилах, нийтийн хүртээл болгох асуудлыг хариуцна.

3.7.3. Сэтгүүлд зохиогчоос ирүүлсэн эх материал, гишүүдийн гаргасан дүгнэлт, санал, дугаар, хэвлэх хувь, Зөвлөлийн тайлан, мэдээллийг архивлан хадгална.

3.8. Зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

3.8.1. Сэтгүүлд нийтлэх бүтээлийг шинжлэх ухаан, онол, арга зүй, баримт

бичгийн боловсруулалт талаас нь хянан редакторлаж, дүгнэлт гарган холбогдох саналын хамт Хариуцлагатай нарийн бичгийн даргад нь өгнө.

3.8.2. Сэтгүүлд чанартай бүтээл нийтлүүлэх талаар идэвх чармайлттай ажиллана. Сэтгүүлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилна.

3.8.3. Зөвлөлийн гишүүнд сэтгүүлд нийтлэгдэх бүтээлийг хянан тохиолдуулан дүгнэлт гаргах үйл ажиллагааны урамшуулал олгож болно.

3.9. Техник редакторийн үүрэг

3.9.1. Сэтгүүлд нийтлүүлэх бүтээлд тавигдах шаардлага, бүрдэлийг хангуулна.

3.9.2. Сэтгүүлд тавигдах бүтээлийг нэгтгэх, загвар, дизайныг гаргах, өнгө үзэмжийг хариуцна

3.9.3. Сэтгүүлийн хураангуйг Гамшиг судлалын хүрээлэнгийн цахим хуудаст байршуулна.

### **Дөрөв. Сэтгүүлд нийтлүүлэх бүтээлд тавигдах шаардлага**

4.1. Сэтгүүлд нийтлэгдэх эрдэм шинжилгээний бүтээл нь энэ журмын 2 дугаар зүйлд заасан сэтгүүлийн нийтлэлийн бодлого, агуулгад нийцсэн болон хэлбэрийн шаардлага хангасан байна.

4.2. Сэтгүүлд хэвлэгдэх эрдэм шинжилгээний бүтээл нь дараахь төрөлтэй байна.

4.2.1 Эрдэм шинжилгээний өгүүлэл;

4.2.2 Эссэ;

4.2.3 Судалгааны үр дүн, тойм;

4.2.4 Эрдэм шинжилгээний бүтээлийн шүүмж;

4.2.5 Орчуулгын бүтээл

4.2.6 Шинжлэх ухаан, технологи, инновацийн шинэ мэдээлэл

4.3 Энэ журмын 4.2 дахь хэсэгт зааснаас өөр төрлийн эрдэм шинжилгээний бүтээлийн аливаа хэлбэрийг сэтгүүлд хэвлэх эсэхийг Сэтгүүлийн зөвлөл шийдвэрлэнэ.

4.4. Эрдэм шинжилгээний өгүүлэл

4.4.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь ишлэл, тайлбарыг оролцуулан 1500-3750 үгтэй (ойролцоогоор 6-15 нүүр) байна.

4.4.2 Эрдэм шинжилгээний өгүүллийн нэр болон товч агуулгыг /абстракт/ англи, эсвэл орос хэлээр 200 үгэнд багтаан ирүүлнэ.

4.4.3. Эрдэм шинжилгээний өгүүллийг редакцийн шаардлагатай тохиолдолд англи, орос хэлээр хэвлэж болно.

4.4.4. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь ашигласан эх сурвалжаас заавал эшлэл авна.

4.4.5. Эрдэм шинжилгээний өгүүллийн эхэнд 5-аас доошгүй түлхүүр үгийг монгол ба англи хэлээр бичсэн байна.

4.5. Эссе

4.5.1 Эссэ нь гамшиг судлалын шинжлэх ухааны хүрээн дэх аливаа асуудлаар өөрийн үзэл бодол, чөлөөт сэтгэлгээг шинжлэх ухаанчаар илэрхийлэн бичсэн байна.

4.5.2 Эссэ нь 1000-4000 үгтэй байна. Хэлбэрийн шаардлагын хувьд эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлагыг нэгэн адил баримтална.

4.6. Судалгааны үр дүн, тойм

4.6.1 Судалгааны үр дүн, тойм гэдэгт гамшиг судлалын шинжлэх ухааны хүрээн дэх аливаа төсөл, бодлогын судалгааны тайлан, үр дүн, танилцуулга, тойм хураангуйг ойлгоно.

4.6.2 Сэтгүүлд нийтлэгдэх судалгааны үр дүн, тойм нь эрдэм шинжилгээний өгүүлэлтэй нэгэн адил хэлбэрийн шаардлагыг хангасан байна. Судалгааны үр дүн, тойм нь хураангуй, түлхүүр үг, оршил, үндсэн хэсэг, дүгнэлт, зөвлөмж, ном зүйн жагсаалтыг оролцуулалгүйгээр 1000 -4000 хүртэл үгтэй байна.

4.7. Эрдэм шинжилгээний бүтээлийн шүүмж

4.7.1 Бүтээлийн шүүмжийг зохиогчоос өөр судлаач бичсэн байна.

4.7.2 Шүүмж нь тухайн бүтээлийн шинжлэх ухааны үнэ цэнэ, шинжлэх ухаанд оруулах хувь нэмэр, практик болон онолын ач холбогдолд үнэлэлт өгсөн байх бөгөөд харин зохиогчид нь субъектив байдлаар дүгнэлт хийхээс ангид байвал зохино.

4.7.3 Шүүмжийг гамшиг судлалын шинжлэх ухааны хүрээн дэх эрдэм шинжилгээний бүтээлд (нэг сэдэвт зохиол, өгүүлэл, илтгэл гэх мэт) мөн энэ салбарын бодлого, хөтөлбөр болон эрхзүйн баримт бичигт бичиж болно. Сурах бичиг, магистр, докторын зэрэг горилох бүтээлд өгөх шүүмж хамаарахгүй.

4.8 Сэтгүүлд нийтлэгдэх бүтээл нь түүний төрлөөс үл хамааран дараахь ерөнхий шаардлагыг хангасан байвал зохино.

4.8.1 Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлж буй бүтээл нь урьд өмнө ижил төрлийн гадаад болон дотоодын сэтгүүлд нийтлэгдэж, нийтийн хүртээл болоогүй байна.

4.8.2 Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлэх аливаа бүтээл нь хэл зүйн хувьд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тавигдах шаардлага хангасан байх бөгөөд эрдэм шинжилгээний бүтээлийн төрлөөс үл хамааран зохиогчийн эрхийг нэн тэргүүн хүндэтгэн үзэж эшлэл, зүүлт авсан, зохиогчийн эрхийн зөрчилгүй байна.

4.8.3 Бүтээлд зохиогчийн нэр, эрдмийн зэрэг цол, эрхэлдэг ажил, цахим шуудан болон холбогдох утасны дугаарыг ирүүлнэ.

4.8.4.Сэтгүүлд нийтлүүлэх бүтээлийг Microsoft Word програмаар бичсэн 12 pt хэмжээтэй Times New Roman фонтоор, мөр хоорондын зай 1-ээр бэлтгэсэн байна. Бүтээлийг А-4 хэмжээний хэвлэсэн болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

4.8.5. Зураг, график, схемийг цахим болон хэвлэмэл байдлаар ирүүлнэ.

### **Тав. Бүтээл хүлээн авах, хэвлэх эсэх дүгнэлт гаргах**

5.1. Бүтээл хүлээн авах

5.1.1. Шаардлага хангасан бүтээлийг хариуцлагатай нарийн бичгийн дарга 4 ба 9 дүгээр сарын 1-нээс 15-ны хооронд хүлээн авна.

5.1.2. Зохиогч нийтлүүлэх бүтээлийн эхийг сэтгүүлийн цахим хаягаар болон биеээр хүрэлцэн ирж хүлээлгэн өгөх бөгөөд ингэхдээ бүтээлийг хүлээн авсан бүртгэлд хүлээлгэн өгсөн он, сар, өдөр, цаг, бүтээлийн нэр, хуудасны тоо зэргийг тэмдэглэн, хүлээлгэн өгсөн, хүлээн авсан хүн гарын үсэг зурж баталгаажуулна.

5.1.3. Бүтээлд тавигдах шаардлагыг хангаагүй бүтээлийг хүлээн авахаас татгалзаж болох бөгөөд хүлээн авсан боловч түүнийг сэтгүүлд нийтлэхгүй байж болно.

5.2. Бүтээлийг хэвлэх эсэх дүгнэлт гаргах

5.2.1. Сэтгүүлийн харицлагатай нарийн бичгийн дарга зөвлөлийн аль нэг гишүүнд сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээлд мэргэжлийн түвшинд хяналтыг хийлгэхээр хүргүүлнэ.

5.2.2. Зөвлөлийн гишүүн зохиогчийн сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээлийг агуулгын хувьд хянаж уг бүтээлийг цаашид сэтгүүлд нийтлэх эсэх талаарх дүгнэлт, эсхүл цаашид бүтээлийг сайжруулах талаарх саналын хамт нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

5.2.3. Зөвлөлийн гишүүн нь сэтгүүл хэвлэгдэн гарахаас 1 сарын өмнө бүтээлийг хэвлэх эсэх дүгнэлтийг гаргасан байвал зохино. Хэрэв дурьдсан хугацаанд зөвлөлийн гишүүн бүтээлд дүгнэлт гаргаагүй бол уг бүтээлийг сэтгүүлийн дараагийн дугаарт нийтлэж болно.

5.2.4. Зөвлөл нь бүтээлийг хэвлэх эсэх талаарх мэдэгдлийг зохиогчид хүргүүлнэ.

### **Зургаа. Сэтгүүлийг хэвлэх ба түгээх**

6.1. Сэтгүүлийн хэвлэлт

6.1.1. Сэтгүүлийг В4 хэмжээтэйгээр монгол хэлээр хэвлэнэ.

6.1.2 Сэтгүүлийг хагас жилд нэг удаа эрхлэн гаргана. Шаардлагатай тохиолдолд сэтгүүлийн тусгай дугаарыг эрхлэн гаргаж болно.

6.1.3 Сэтгүүлийн талаарх мэдээлэл, нийтлэгдсэн бүтээлийн хураангуйг Гамшиг судлалын хүрээлэнгийн цахим хуудаст байршуулах бөгөөд цаашид бүрэн эхээр нийтэлж болно.

6.2. Сэтгүүлийг түгээх, олон нийтэд таниулах

6.2.1. Сэтгүүлийг Онцгой байдлын байгууллагын нийт алба хаагч, эрдэмтэн, судлаач, суралцагч нарт нэн тэргүүнд хүргэнэ. Холбогдох төрийн байгууллага, их, дээд сургууль, судалгааны хүрээлэн, төвд түгээнэ.

6.2.2. Бүтээлээ хэвлүүлсэн зохиогчид тухайн дугаарын сэтгүүлийн нэг хувийг үнэгүй олгоно.

6.2.3. Сэтгүүлийн нэр хүндийг өсгөх, мэргэжлийн хүрээнд нийтэд хүртээмжтэй болгох, зохиогч болон нийтлэгдсэн бүтээлийг сурталчлах, мэргэжлийн хүрээнд таниулах ажлыг Редакцийн зөвлөл зохион байгуулна.

### **Долоо. Сэтгүүлийн санхүүжилт**

7.1 Сэтгүүлийн санхүүжилт нь Онцгой байдлын ерөнхий газрын төсөвт үндэслэнэ.

7.2 Сэтгүүл нь санхүүжилт олох, өөрийгөө санхүүжүүлэх чиглэлээр бусад байгууллага, хувь хүнтэй хамтарч ажиллаж болно.

7.3. Бүтээлийг уншиж, хянан тохиолдуулсан Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, эрдэмтэн, судлаачдад болон сэтгүүл хэвлэхтэй холбогдсон техник ажилд оролцсон алба хаагчдад жилийн эцэст зохих хэмжээний урамшуулал олгоно.

### **Найм. Бусад**

8.1. Сэтгүүлийг хэвлэх, дэвтэрлэх, үдэх ажиллагааны явцад хуудас солигдох, үсэг бүдэг гарах, өнгө үзэмж муу, техник алдаа гарах, үг, үсэг, найруулгын илэрхий алдаа гарснаас үүдэн гарч болох нэмэлт зардал, цаг хугацааны алдагдал, хохирлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

8.2. Уг журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, сэтгүүлийн редакцийн зөвлөл гаргаж болно.